

Эмэгтэйчүүдийн ба ядуурал

Ж. Должинсүрэн

УСГ-ийн мэргэжилтэн

Идэх хоол, өмсөх хувцсаар дутагдан орон байргүй ам зуулгын наад захын хэрэгцээт зүйлсээр гачигдан ядууралд орох нь эрэгтэй, эмэгтэй хэний ч ялгаагүй санаа сэтгэлийг зовоосон амьд явах, аж төрөх хувь заяаны нэн эгзэгтэй асуудал юм.

Эмэгтэй хүнийг зөвхөн хүн амын нөхөн үржихүйд гүйцэтгэж буй үүргийнх нь хүрээнд бус гэр орны өдөр тутмын амьдралыг залгуулагч гол хүчин болохын зэрэгцээгээр ажиллаж хөдөлмөрлөн нийгмийн амьдралд эрэгтэйчүүдийн нэгэн адил оролцож давхар ачаалал үүрч явдаг бие даасан хувь хүний нь хувьд авч үзэж, эрх ашиг сонирхлыг нь хамгаалах, зах зээлийн нөхцөлд амьдрах чадварыг тэдэнд эзэмшүүлэх, ядуурлаас сэргийлэн хамгаалах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хорьдугаар зууны үе хүртэл Монголын эмэгтэйчүүдийн ихэнх нь бараг феодалын нийгмийн үеийн байдлаар амьдарч, нийгэм эдийн засгийн талаар газар эзэмшигч хөрөнгөтнүүд болон ламын шашны эрхшээлд байжээ. Ийм байдал Манжын дарлалын хоёр зуу гаруй жилийн турш үргэлжилсэн ба түүнээс өмнө эмэгтэйчүүд харьцангуй тэгш эрх эдэлж байжээ. Хөвгүүдийн дөрөвний нэг нь ламын шашинд орж, эхнэр авдаггүй байсан нь Монголд төрөлтийг хязгаарлаж, зарим талаар хөдөөд хэт ядуурлыг багасгаж байв.

Эмэгтэйчүүдийн феодалын үеийн байдал социализмын үед эрс өөрчлөгдсөн. 1921 оны хувьсгалын дараа эмэгтэйчүүд боловсрох, ажил эрхлэх талаар эрэгтэйчүүдийн адил боломжтой болсон. Эмэгтэйчүүд гэрлэлтээ цуцлуулах боломжтой болсон. Эмэгтэйчүүдийн мэдлэг чадварт итгэж тэдний амьдрал завсардах буюу ахин дэвшихэд нь саад учруулахгүйн тулд хүүхэд асрах үйлчилгээг улсаас бий болгосон байна. 1930-аад онд эмэгтэйчүүд ихээхэн амжилт олж, тэдний талаар их зүйл хийжээ. 1923 онд Монголын анхны дунд сургуульд тавхан бүсгүй сурагч байсан аж. 1928 он гэхэд 558 бүсгүй дунд сургуульд сурах болжээ. Их сургууль анх байгуулагдсаны дараа 1940-өөд оны

эхээр төгсөгчдийн 2400 нь эмэгтэйчүүд байжээ. 1969 он гэхэд бүх эмэгтэйчүүдийн 76 хувь нь бичиг үсэгтэй, 1989 он гэхэд бичиг үсэгтэй эмэгтэйчүүдийн хувь 86-д хүрч нэмэгдсэн байна.

Эмэгтэйчүүдийн ядуурлын өнөөгийн байдал

Улс орон зах зээлийн харилцаанд шилжиж буй энэ үед манай орны нийгэм эдийн засгийн амьдралд бий болсон олон талт хямрал бэрхшээл нь юуны түрүүнд эмэгтэйчүүдийн амьдрал ахуйд хүндээр тусч байна. Өнөөдөр ажилгүйчүүдийн 50.7 хувь нь эмэгтэйчүүд буюу 28.1 мянган эмэгтэй хөдөлмөрийн захад бүртгүүлж ажил хайж байна. Энэ нь хөдөлмөрийн чадвартай эмэгтэйчүүдийн хувь болж байна. Өмч хувьчлал орон тооны цомхотголоос олон зуун эмэгтэйчүүд олон хүүхэдтэйн улмаас эрт тэтгэвэрт гарч ажлын байрнаасаа шахагдан ажилгүйчүүдийн эгнээнд орсон юм. Энэхүү ажилгүйдэл нь эмэгтэйчүүдийг ядууралд оруулж буй нэг гол шалтгаан болж байна. Сүүлийн нэг жилийн дотор төрөлт болон төрөхийн улмаас эндсэн эхийн тоо аль аль нь буурсан боловч эндсэн эхчүүдийн 70-аад хувь нь амьжиргааны доод түвшинд амьдарч байна.

Гэр бүл салалт сүүлийн хоёр жилд өсөх хандлагатай байна. 1996 оны байдлаар өрх толгойлсон эмэгтэйчүүд 46.0 мянга байгаагийн 78.7 хувь нь 16 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүд байна. Өрх толгойлж амьдарч байгаа эмэгтэйчүүдийн нэлээд хэсэг нь орлогын эх үүсвэргүй, нөгөө нэг хэсэг нь тэтгэвэр тэтгэмж болон хөдөлмөрийн хөлс нь өрхийн гишүүдийн наад захын хэрэгцээг хангаж чадахгүй хүмүүс байна. Өнөөдөр орон сууц, түлш, цэцэрлэг ясли, дээд сургуулийн сургалтын төлбөр, хичээлийн хэрэгслийг худалдан авах чадваргүй эмэгтэйчүүд олон байна.

1996 оны байдлаар улсын хэмжээнд бүтэн өнчин хүүхэд 4197, хагас өнчин 57395 хүүхэд байна.

Хүснэгт1

Сургууль завсардсан хүүхдийн тоо

ОН	1995	1996
Бүгд	46342	48697
үүнээс: эмэгтэй	18838	20723

Сургууль завсардсан үндсэн нэг шалтгаан дотуур байрны нөхцөл муудаж хүүхдийн холоны зардлын зарим хэсгийг эцэг эхээс нь авах болсонтой холбоотой гэсэн дүгнэлт гарч байгаа юм.

Цэцэрлэг яслийн тоог цөөрч, сүүлийн 2 жилд улсын хэмжээнд 30 шахам ясли хаагдаж, (1990 оныхоос 400 гаруй ясли хаагдсан) хөдөөд яслийн тоо 80 орчим хувиар буурсан нь ялангуяа амьдралын түвшин доогуур, өрх толгойлж амьдардаг олон хүүхэдтэй эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд сөрөг нөлөө үзүүлж байгаа бас нэгэн баримт юм.

Хөдөөгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламжийн хүртээмж үйлчилгээний төрөл буурсан нь ялангуяа малчин эмэгтэйчүүдийн амьдралд муугаар нөлөөлж байна. Малчин эхчүүдийн төрөхийн өмнөх байр өмнөх эдийн засгийн үеэс багассан, 1996 онд улсын хэмжээгээр нийт 269 эхийн амрах байр байгаагийн зөвхөн 94 нь зориулалтын байранд байгаа ба 175 нь зориулалтын бус гэрт болон эмнэлэгт байна.

Улсын Статистикийн Газрын 1996 оны мэдээгээр нийт малчин өрхийн 90.7 хувь нь цахилгаан гэрэлгүй, 90.4 хувь нь телевизоргүй, 37.4 хувь нь радио хүлээн авагчгүй байна. Хувийн малтай өрхийн 14.3 хувь нь 10 хүртэл, 30.4 хувь нь 11-50 малтай байна.

Хөдөөгийн малчин өрхийн олонхийн амьдралын түвшин доогуур, ахуй амьдралын хангамж муутай байгаа нь хүмүүсийн сурч боловсрох, соёлжих боломжийг боогдуулж мэдээллээр гачигдаж улмаар оюуны хоосролд оруулахад хүргэж байна.

Өмнөх эдийн засгийн үед мал аж ахуй, газар тариаланд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг үнэлэх, нийгэм, соёлын үйлчилгээг өргөжүүлэх, нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамруулах талаар төр, засаг, эмэгтэйчүүдийн байгууллагаас ихэд анхаарч ирсэн юм. Малчин эмэгтэйчүүдийн нийгмийн асуудлыг улс, нэгдэл хариуцаж байв. Монголын эмэгтэйчүүдийн холбооноос Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр жил бүр малчин, төлчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт хийж, ахуйн болон соёлын үйлчилгээг

зохион байгуулдаг уламжлал бий болсон байв. Тэтгэвэр тогтоолгоогүй малчин эмэгтэйчүүдийн тэтгэвэрийг нөхөн тогтоох ажлыг 1980-аад оны сүүлчээр зохион байгуулжээ.

Харин сүүлийн жилүүдэд мал хувьд очиж, малчид малын эзэд болцгоосон. Энэ нь эдийн засгийн чухал алхам бодовч эмэгтэйчүүдийн цаггүй хөдөлмөрийг улам нэмэгдүүлж, ачааллыг ихэсгэсэн. Хувьчлахаас өмнө эмэгтэйчүүд ихэвчлэн саальчнаар нэг төрлийн малтай аж ахуйн нэгж дээр ажилладаг байсан. Ийм учраас хөдөөгийн эмэгтэйчүүд өнөөдөр өдөрт урьдынхаас 3-4 цаг илүү хөдөлмөрлөх тооцоо гарч байна. Мөн хоол ундаа хийх, угааж арчих, настайчууд хүүхдээ халамжлах шаардлагатай болдог тул эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол бага унтаж байна. Малчид зах зээлийн нөхцөлд малынхаа бүтээгдэхүүнийг борлуулах зохистой нөхцөл бий болоогүй байгаа нь зах зээлээс хол амьдардаг, мал цөөхөнтэй, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн амьдралыг ихэд хүндрүүлж байна.

Хөдөөгийн эмэгтэйчүүдэд мэдээлэл хүргэхэд ихээхэн бэрхшээлтэй болсон. Цахилгаан хэрэгсэл байхгүй, хөдөлмөр хөнгөвчилсөн гэр ахуйн техник хэрэгсэл ахуйд бараг нэвтрээгүй зэрэг нь эмэгтэйчүүд тодорхой үнэлгээгүй гэрийн хөдөлмөрт их цаг зарцуулахад хүргэж байна. Хоол хүнс худалдаж авахын тулд эмэгтэйчүүд малаа худалдаачдад зарж, малын нөөц нь хорогдож байгаа тул аажимдаа тэд эдийн засгийн талаар бие даасан байдлаа алдаж ядуурч байна.

Ер нь манай улсад эмэгтэйчүүдийн гэр орны хөдөлмөрийн үнэлгээг тодруулах талаар тодорхой судалсан, албан ёсоор үнэлж тооцож байгаа зүйл одоогоор байхгүй байгаа ба энэ бүхнээс үзэхэд эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг хөнгөвчлөх, шинэ технологи нэвтүүлэх, тэдний нийгэм ахуйн нөхцлийг сайжруулах асуудал өнөө үед нэн чухлаар тавигдаж Улсын Статистикийн Газраас хүйсийн статистикийг бий болгон хөгжүүлэх талаар анхаарч эхэлж байна.

Шилжилтийн энэ үед нийгмийн дунд гэмт хэрэг зөрчил нэлээд өссөн ба архидалт, хүчирхийлэл нэмэгдэн, эмэгтэйчүүд эрүүгийн

хэрэгт холбогдох, архидаг согтуурах, садар самуунд татагдан оролцох нь урьд өмнө байгаагүйгээр нэмэгдэж байна. Үнд бидний залуу хойч ирээдүй болох охид бүсгүйчүүд их хамрагдаж байгаа нь хамгийн эмзэг асуудал юм. Ийм охид олонхи нь амьдрал ядуу айлын хүүхдүүд байна. Орон гэргүй тэнүүчилж улмаар ёс суртахууны элдэв доголдолд орж Монгол эмэгтэйн уламжлалт ёс заншлыг огоорон биеэ үнэлж хөнгөн маягийн амьдралаар амьдрах замыг сонгож буй охид амьдрах орон байр эрэн хот, хөдөөд хэсүүчлэн үр хүүхдээ хаяж орхин яваа залуу бүсгүйчүүд ч цөөнгүй үзэгдэх боллоо. Энэ бүгд нь зах зээлийн эдийн засагт шилжиж буй энэ үед нийгмийн зүгээс хүнд тавих анхаарал халамжийг нэмэгдүүлэх, ялангуяа амьжиргааны доод түвшинд амьдарч буй хүн амын эмзэг хэсэгт төрөөс халамж үзүүлж, тэдэнд энх амгалан аж төрөх нөхцлийг бүрдүүлэхэд төрөөс онцгой анхаарах нь чухал юм. Ингэхийн тулд бэрхшээл хүндрэлийг давж гарах сэтгэл зүйн бэлтгэл, хүмүүжлийг юуны түрүүнд залуучуудад төлөвшүүлэх, бие даан амьдрах мэдлэг, оюун санааны болон бие бялдрын нөөц хүч чадлаараа өөрөө өөрийгөө авч явах ухаан, өөртөө итгэх итгэлийг тэдэнд бий болгох нь туйлын чухал юм.

Эмэгтэйчүүдийг ядууралд оруулж буй нэг гол шалтгаан нь ажилгүйдэл юм. Энэ нь ялангуяа өрх толгойлсон, олон хүүхэдтэй эмэгтэйчүүдийн амин зуулгад шууд нөлөөлөх асуудал юм. Түүнчлэн тогтмол орлоготой, олон хүүхэдтэй хэт ядуу эмэгтэйчүүд болон настай эмэгтэйчүүдийн нөхцлийг сайжруулах асуудал бэрхшээлтэй байх бололтой. Бага насны хүүхэдгүй эмэгтэйчүүд сүүлийн үед хувийн аж ахуйтан болох явдал их байна. Хангалттай мөнгө хуримтлуулж үйлдвэр үйлчилгээ явуулах хайдвар тавьж худалдаа наймаа хийж байна. Ийм хандлага үргэлжилбэл сургууль төгсөгчид, ажилгүй болон бүрэн бус ажлын өдрөөр эмэгтэйчүүдэд зориулж ажлын байр бий болгох боломжтой юм.

Эмэгтэйчүүдийг ядуурлаас гаргах арга зам

Засгийн газраас нэн тэргүүнд анхаарвал зохих асуудалд ядуурлыг бууруулах чиглэл онцгой байр суурь эзэлж байна. 1990 оноос шилжилтийн үе эхэлсэн ба 1990 оноос эхлэн Монгол улс

ядуурлын асуудлыг анхаарч үзэж ядуурлыг бууруулах нэлээд дорвитой хөтөлбөр хэрэгжүүлж байна. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг 1994 оны 6 дугаар сард бэлэн болгож 2000 он гэхэд ядуурлын хувь хэмжээ 26 хувийг 10 хүртэл бууруулах зорилт агуулжээ.

Ажлын байр нэмэгдүүлэх макро эдийн засгийн бодлого баримталж зах зээлийн шинэ шаардлага хангах түвшинд хүртэл ядуучуудыг бэлтгэх арга хэмжээ авах, хувийн салбарыг түргэн хөгжүүлэх, жижиг аж ахуй эрхлэгч болон эмэгтэйчүүдийг бага хэмжээний зээл авах боломжтой болгох, хөдөлмөрийн захын шинэчлэлтийн үед ажил олж чадахгүй байгаа хүмүүсийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тусгажээ.

Хүүхэд болон эмэгтэйчүүд мэдээж эмзэг давхрага мөн. Монгол байгаа нэн ядуу өрхийн гуравны нэг нь эмэгтэйчүүдийн толгойлсон өрх тул чиглэлийг маш анхааралтай хийх хэрэгтэй. Нийгмийн халамжийн тусламжийг өнөөг хүртэл янз бүрийн төрлийн хүмүүст (тухайлбал олон хүүхэдтэй эмэгтэйчүүд, олон төрөлттэй г.м) үзүүлж байна.

Засгийн газраас нийгмийн эмзэг хэсэгт

- бүтэн ба хагас өнчин хүүхэд

- тахир дутуу иргэд

- халамжлах хүнгүй өндөр настангууд

- ажилгүйчүүд

- цөөхөн малтай малчид

- олон хүүхэдтэй эмэгтэйчүүдээр толгойлуулсан өрх орсон.

Амьжиргааны түвшингийн судалгаагаар эмэгтэйчүүдээр толгойлуулсан өрхийн хүмүүсийн 60 хувь нь ядуу байхад эрэгтэйчүүдийн толгойлсон өрхийн 30 хувь нь ядуурлын түвшингээс доогуур амьжиргаатай байна.

Энэ нь эмэгтэйчүүдээр толгойлуулсан өрх нь эмзэг хэсэг гэдгийг харуулж байна. Монголын нийт өрхийн 18.4 хувийг эмэгтэйчүүд толгойлдог. Эмэгтэйчүүдээр толгойлуулсан өрхийн хагасаас илүү нь ядуурлын түвшингээс доогуур амьжиргаатай байгааг дээр харсан.

Өрхийн амьдралын түвшин дээшлэх тутам эмэгтэйчүүдээр толгойлуулсан өрхийн тоо буурч байна. Чинээлэг өрхийн 93 хувь нь эрэгтэйчүүдээр, дөнгөж 7 хувь нь эмэгтэйчүүдээр толгойлуулсан байна.

Эмэгтэйчүүдээр толгойлуулсан өрхийн дотор ядуурал их байгаа нь зөвхөн өрхийн тэргүүний хүйсээс хамаарч байгаа биш бас хүний хүчин зүйлийн бусад нөлөө, ажлын байдал, өрхийн хүний чадавхаас бас хамаардаг.

Эрэгтэйчүүдээр толгойлуулсан өрхтэй харьцуулахад эмэгтэйчүүдээр толгойлуулсан өрх нь ажил хийдэг хүн цөөн, ажилгүй хүн олонтой. Ядуу өрх толгойлсон эмэгтэйчүүд боловсролтой байх нь цөөхөн.

Ядуурлын түвшин болон боловсролын байдлаар, хүйсээр

		боловс ролгүй	бага сур- гуулийн	дунд бол овсролтой	дээд	Бүгд
эрэгтэй	1	12.2	62.2	12.8	12.9	100.0
	2	4.0	51.7	16.5	27.8	100.0
	3	4.6	48.0	15.5	31.9	100.0
	4	3.6	39.4	12.6	44.3	100.0
	5	2.6	27.3	12.2	58.0	100.0
	6	4.8	43.9	13.9	37.4	100.0
эмэгтэй	1	19.8	52.0	14.4	13.8	100.0
	2	18.4	46.5	22.5	12.6	100.0
	3	7.7	63.3	9.0	20.2	100.0
	4	12.7	45.0	11.3	31.0	100.0
	5	2.0	23.7	6.8	67.5	100.0
	6	13.9	49.0	13.6	23.5	100.0

Эх сурвалж: МАТС-наас авав.